



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/219

Мөрөн сум

Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дүгээр тушаал, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 03 ны өдрийн 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд малчдыг мэдээллээр хангах зорилготой “Хоймор нутгийн малчид” зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Мөрөн суманд зохион байгуулсугай.

2. Тус арга хэмжээнд малчдыг өргөн хүрээтэй хамруулж, идэвхтэй оролцохыг сумдын засаг дарга нарт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т, Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Базар)-т нарт тус тус даалгасугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 6,000,000 (Зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6710010073